



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 10/06

Арвайхээр сум

**Ойгоос 2026 онд бэлтгэх модны
хэмжээ тогтоох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, "Ойгоос 2026 онд бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай" Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн Сайдын 2025 оны А/581 дүгээр тушаалыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрээс 2026 онд ойгоос бэлтгэх модны хэмжээг нэгдүгээр хавсралтаар, Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын ойн сангаас бэлтгэх модны хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аж ахуйн нэгж, нөхөрлөл, иргэдэд ахуйн зориулалтаар бэлтгэх модны хэмжээг хууль тогтоомжид заасан тоо хэмжээгээр төлөвлөн батлуулах, ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах, эрхийн бичиг олгох ажлыг зохион байгуулж ажиллахыг ой бүхий сумдын Засаг дарга, Сум дундын Ойн анги (Д.Очирхуяг) нарт даалгасугай.

3.Ойгоос бэлтгэсэн хэрэглээний болон түлээний модыг Нийслэл, Төв аймгаас бусад аймаг сум руу тээвэрлэх, борлуулах, зөвшөөрөл олгох, эрхийн бичгээр хангахыг Сум дундын Ойн анги (Д.Очирхуяг)-д, тогтоолын биелэлтэд хяналт тавьж мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Байгаль орчны газар (Т.Эрдэнэбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

4.Төв суурин газруудын айл, өрхийн хэрэгцээт түлээний модыг төвлөрсөн журмаар Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрээс 2026 онд бэлтгэх модны хуваарьт багтаан бэлтгэж нийлүүлэхийг Бат-Өлзий сумын Засаг дарга Н.Орхонтуул, Сум дундын Ойн анги (Д.Очирхуяг) нарт даалгасугай

ДАРГА



НАРАНГАРАВ

622501113



Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны № дүгээр сарын 28-ны өдрийн
107 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРЭЭС 2026 ОНД ОЙГООС БЭЛТГЭХ МОДНЫ ХЭМЖЭЭ

Сумын нэр	Модны төрөл	Ойгоос мод бэлтгэх тоо хэмжээ			Ойгоос мод бэлтгэх нийт талбайн хэмжээ (га)	Үүнээс			
		Шинэс (м3)	Хэрэглээ(м3)	Түлээ (м3)		Цэвэрлээний огтлолт	Арчилгааны огтлолтоор	Уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар	Ой Цэвэрлээний ажлаар
1. Бат-Өлзий	18530	3230	15300	18530	192	14	10	-	168
2. Зүүнбаян-Улаан	2600	300	2300	2600	10	2	-	-	8
3. Уянга	2420	120	2300	2420	10	2	-	-	8
4. Хужирт	3100	400	2700	3100	10	2	-	-	8
5. Хархорин	800	200	600	800	8	-	-	-	8
Дүн	27450	4250	23200	27450	230	20	10	-	200



Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 1- дүгээр сарын 28-ны өдрийн
10- дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ОРХОНЫ ХӨНДИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗРЫН ОЙН САНГААС БЭЛТГЭХ МОДНЫ ХЭМЖЭЭ

д/д	Сумын нэр	Модны төрөл, зориулалт	Ойн цэвэрлэгээний огтлолт	Ойн цэвэрлэгээний ажил
1.	Бат-Өлзий	Хэрэглээ	1500 м3	2000 м3
		Түлээ	-	3000 м3
		Талбай	40 га	100 га
	Дүн	Нөөц	1500 м3	5000 м3
		Талбай	40 га	100 га